МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2018.07.05 № 2/2792

танай ____________-ны № ______________-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР, ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВИЙН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Нийгмийн баталгааг хангах сар болгон зарлах тухай” А/264 дүгээр тушаалыг хавсралтаар хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

Тушаалын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх төлөвлөгөөний биелэлт, тайланг Төрийн захиргааны удирдлагын газарт 2018 оны 09 дүгээр сарын 15-ны өдөрт багтаан ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудас

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Э.СОДНОМЖАМЦ

083058

# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
# ТУШААЛ

2018 оны 07 сарын 02 өдөр　　　　Дугаар А/264　　　　Улаанбаатар хот

Нийгмийн баталгааг хангах сар
болгон зарлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жил бүрийн 8 дугаар сарыг Эрүүл мэндийн ажилтны “Нийгмийн баталгаа”-г хангах сар болгон зарласугай.

2. Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эрүүл мэндийн ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхийг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлж байхыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай.

САЙД　　　　Д.САРАНГЭРЭЛ

061119